

Хүүхдийн эрүү нүүрний мэс заслын тасагт эмчлүүлэгчдийн өвчлөлийн бүтэц

Пүрэвсүрэн Б.¹, Аянга Г.², Норовпил Ц.¹

¹"Ач" Анагаах ухааны их сургууль, ²Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв

Email: purevsuren.lfc@gmail.com

Abstract

The structure of disease among children department of maxillofacial surgery

Purevsuren B.¹, Ayanga G.², Norovpil Ts.¹

¹"Ach" medical university, ²National Center for Maternal and Child Health

Email: purevsuren.lfc@gmail.com

Introduction

The department of Maxillofacial surgery of the National Center for Maternal and Child Health (NC-MCH) has a nationwide tertiary medical service on the patients who is with congenital orofacial anomalies, facial injury, nonmalignant tumors of this area, and inflammations of maxillofacial area following dental caries and other reasons as well. For the last years nationwide the number of inpatient of the department has been growing constantly meaning that the necessity of medical care for our countries for children is also growing. Therefore by studying and analyzing the structure of the illness of the department will be able to determine the most frequent orofacial illness among children in our country, to prevent them, define the treatment plan.

Aim:

To clarify what disease in the Maxillofacial area mainly occurs among Mongolian children.

Materials and Method:

We included all patients who underwent emergency and planned surgery in the department of Maxillofacial surgery, NCMCH between 2014-2015.

We used descriptive and case-control method based on the information of inpatients history record between 2014.01.01-2015.01.01 at the department of Maxillofacial surgery, NCMCH and using our own –designed, pre-screened survey card.

Statistical data processing is done using Microsoft Office-2017 and SPSS for windows programs, and the results are shown illustrated method. The survey identified the incidence and frequency of each disease classification, and analyzed the characteristics of the child's age, sex, and residency.

Result

The most of patients, who involved in this study were with the inflammation of maxillofacial area (57%), and the congenital orofacial clefts (24.4%).

In total 3300 children from 0-18 years old admitted at the department of Maxillofacial surgery and Infants study for orofacial surgery treatment were involved in this study.

Among which were 1803(54.6%) male, 1497(45.4%) female. Considering the residency, 2525(76.5%) children from Ulaanbaatar and 775 (23.5%) children from countryside. The most of patients, who involved in this study, were with the inflammation of maxillofacial area (57%), and the congenital orofacial clefts (24.4%).

Conclusion

Based on the result of our study the highest incidence among the participants was inflammation of maxillofacial area with 57% in which odontogenic periostitis was the most frequent with 21.6%. Congenital orofacial clefts and disorders was the 2nd most frequent with 24.4%. Inflammation of maxillofacial area was most frequent in 0-2 age group with 33.7%, and mostly in male. Considering there were residency with 83.2% highest in Ulaanbaatar and mostly in Bayanzurkh district with 24.7%.

Key words: Cleft lip and palate and orofacial clefts, inflammation of maxillofacial area, odontogenic periostitis, structure of disease

Pp. 88-93, Figures 6, References 16

Үндэслэл

Эрүү нүүрний мэс заслын (ЭНМЗ) салбар нь уруул тагнайн болон нүүрний төрөлхийн сэтэрхийнүүд, чихний дэлбэнгийн гаж хөгжил зэрэг нүүрний хэлбэр алдагдуулсан төрөлхийн хөгжлийн гажгууд, нүүр, хүзүү, толгойн гэмтэл, үрэвсэл, нүүрний мэдрэл, эрүү чамархайн үе, шүд шүдлэлтийн гажгуудын мэс заслын эмчилгээ болон эрүү нүүр, хүзүү толгойн орчмын хортой, хоргүй хавдруудын мэс заслын эмчилгээг хариуцдаг мэс заслын нэгэн томоохон салбар шинжлэх ухаан билээ¹.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (ЭХЭМҮТ)-ийн ЭНМЗ-ын тасаг нь хүүхдэд үзүүлэх эрүү нүүрний мэс заслын тусламж, үйлчилгээг улсын хэмжээнд, 3-р шатлалын түвшинд үзүүлж байна.

Одоо тус тасагт эрүү нүүр орчмын төрөлхийн гаж хөгжил, шүдний болон шүдний бус гаралтай өвөрмөц ба өвөрмөц бус үрэвсэл, эрүү нүүрний гэмтэл, яс ба зөөлөн эдийн хоргүй хавдар, эрүү чамархайн үений болон нүүрний мэдрэлийн эмгэгүүд зэрэг нийт 44 төрлийн² өвчлөлийг оношлох, эмчлэх тусламж үйлчилгээг амбулаториор болон тасагт хэвтүүлэн эмчилж байна.

Улсын хэмжээнд хүүхдийн ЭНМЗ-ын чиглэлийн тусламж, үйлчилгээ шаардлагатай өвчлөлийн тоо жил ирэх тусам нэмэгдэж буй нь тухайн салбарын эмч мэргэжилтнүүдийн хийсэн судалгааны ажлууд^{3,4,5,6} болон тухайн тасгийн өвчлөлийн талаарх статистик мэдээллүүдээс⁷ харагдаж байгаа бөгөөд энэ нь хүүхдийн дунд эрүү нүүрний мэс заслын тусламж шаардлагатай эмгэгийн тохиолдол нэмэгдэж буйг илтгэж байна.

Р.Баясгалан нарын судалснаар ЭХЭМҮТ-ийн ЭНМЗ-ын тасагт нийт хэвтэн эмчлүүлэгчдийн дунд шүд цоорох өвчний хүндрэл болох эрүү нүүр орчмын үрэвслийн эзлэх хувь 1999 онд 29.1%, 2000 онд 32.0%, 2006 онд 30.6%-ийг тус тус эзэлж байсан⁸ бол судлаач Б.Төрболд нарын судалснаар 2014-2016 онуудад хэвтэн эмчлүүлэгчдийн 36.77%-ийг шүд цоорох өвчний хүндрэл болох эрүү нүүр орчмын үрэвсэлт өвчин эзэлж байна⁹.

Манай улсад хүүхдэд тохиолдох ЭНМЗ-ын зарим өвчлөл, тэдгээрийн тархалт, эмчилгээний аргын талаар цөөнгүй судалгааны ажлууд хийгдэж байсан байна. Харин энэ салбарын өвчлөлийн бүтцийн талаар хийсэн судалгааны ажил үгүй байгаа нь энэхүү судалгааг явуулах үндэслэл боллоо.

Зорилго

Хүүхдэд тохиолдож буй ЭНМЗ-ын өвчлөл, түүний тохиолдлыг бусад хүчин зүйлтэй холбон судлах.

Зорилт:

1. ЭХЭМҮТ-ийн ЭНМЗ-ын тасагт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тохиолдлыг судалж тогтоох
2. Хүүхдэд зонхилон тохиолдож буй ЭНМЗ-ын өвчлөлийг нас, хүйс, харъяалалтай холбон судалж тогтоох

Материал, арга зүй

Дескриптив, нэгэн агшны загвараар хийсэн энэхүү судалгааг ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлгийн ЭНМЗ-ын тасагт 2014.01.01–2015.12.31 хооронд хэвтэн эмчлүүлэгчдийн өвчний түүхээс авсан мэдээллүүдийг тусгасан, өөрсдийн боловсруулж, урьдчилан шалгасан асуумж бүхий судалгааны картыг ашиглан явууллаа.

Судалгаанд хамрагдагсдын харъяаллыг судлахдаа Улаанбаатар, орон нутаг гэж 2 бүлэглэн Улаанбаатар хотын хувьд Багануур, Багахангай, Баянгол, Баянзүрх, Налайх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй гэсэн есөн дүүргээр ангилах бөгөөд хөдөө орон нутгийг газар зүйн хувьд баруун, хангайн, төвийн, зүүн гэсэн дөрвөн бүсчлэлийн ангилалыг¹⁰ ашиглав. Үүнд:

- Баруун бүсэд: Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймаг
- Хангайн бүсэд: Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл аймаг
- Төвийн бүсэд: Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв аймаг
- Зүүн бүсэд: Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймаг тус тус багтаж байна.

Мөнбидхүүхдийн насаар үрдүгт одорхойлохдоо 1965 оны олон улсын симпозиумаас батлаж одоог хүртэл өөрчлөгдөлгүй хэрэглэгдэж буй хүүхдийн эрүүлийг хамгаалах болон сурган хүмүүжүүлэх ажилд тохиромжтой гэж үздэг насны үечлэлийг ашиглаж бүлэглэв¹¹. Үүнд: 0-2 нас (Бага нас), 3-5 нас (Сургуулийн өмнөх нас), 6-9 нас (Сургуулийн бага анги), 10-13 нас (Сургуулийн дунд анги), 14-18 нас (Сургуулийн ахлах анги).

Хэвтэн эмчлүүлсэн хүүхдийн үндсэн оношыг судлахдаа ЭХЭМҮТ-ийн захирлын зөвлөлийн хурлаар батлагдаж эрүү нүүрний мэс заслын

тасагт баримталдаг “Оношилгоо, эмчилгээний удирдамж”-ийн дагуу өвчлөлийг 6 бүлэг болгосныг² ашиглав. Үүнд:

1. Уруул тагнайн төрөлхийн сэтэрхий болон эрүү нүүр орчмын бусад төрөлхийн гаж хөгжлүүд
2. Эрүү нүүр орчмын үрэвсэлт өвчнүүд
3. Эрүү нүүр орчмын гэмтэл
4. Эрүү-чамархайн үений өвчнүүд
5. Шүлсний булчирхайн өвчнүүд
6. Эрүү нүүр орчмын хоргүй хавдрын өвчнүүд

Мэдээллийн статистик боловсруулалтыг Microsoft Office-2017, SPSS for windows прог-

раммуудыг ашиглан хийж, үр дүнг дүрслэх статистикийн аргаар илэрхийлэв. Судалгаагаар өвчний ангилал тус бүрээр тохиолдол, давтамжийг тодорхойлсон бөгөөд үзүүлэлтүүдийг хүүхдийн нас, хүйс, харьяалалтай нь холбон дүн шинжилгээ хийлээ.

Үр дүн

Судалгаанд 2014-2015 оны хооронд ЭХЭМҮТ-н ЭНМЗ-н тасагт болон нярай судлалын тасагт хэвтэн эрүү нүүрний мэс заслын тусламж авсан 0-18 насны нийт 3300 хүүхэд хамрагдлаа. Үүнээс 1803 (54.6%) эрэгтэй, 1497 (45.4%) эмэгтэй хүүхэд байв (Figure 1).




Figure 1. Sex ratio of study participants

Судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн 2525 нь Улаанбаатар хотынхэнэ нь нийт хэвтэн эмчлүүлсэн хүүхдийн 76.5%–ийг эзэлж, 775 (23.5%) ньхөдөө орон нутгийн харьяалалтай байсан бөгөөд эдгээрийн дийлэнх 334 (44.4%) нь төвийн бүсийн харьяалалтай байлаа.

Судалгаанд хамрагдсан нийт 3300 хүүхдийн 1117 (33.8%) нь бага насны хүүхдүүд, 848 (25.7%) нь сургуулийн өмнөх нас, 779 (23.7%) нь сургуулийн бага анги, 351 (10.6%) нь сургуулийн дунд анги, 205 (6.2%) нь сургуулийн ахлах ангийн хүүхдүүд эзэлж байв (Figure 2).




Figure 2. Age index of study participants

ЭНМЗ-ын тасагт хэвтэн эмчлүүлж мэс заслын тусламж авсан хүүхдийн дийлэнх (33.8%) нь бага насны (0-2 нас) хүүхдүүд байна(Figure 2).

Судалгаанд хамрагдсан нийт 3300 хүүхдийн 1881 нь “Эрүү нүүр орчмын үрэвсэлт өвчнүүд”, 806 нь “УТТС болон эрүү нүүр орчмын бусад төрөлхийн гаж хөгжлүүд”, 225 нь “Эрүү нүүр

орчмын хоргүй хавдрын өвчнүүд”, 223 нь “Эрүү нүүр орчмын гэмтэл”, 110 нь “Шүлсний булчирхайн өвчнүүд”, 1 хүүхэд “Эрүү-чамархайн үений өвчнүүд” бүлэгт хамрагддаг өвчнөөр, харин 54 нь “Бусад” өвчнөөр өвчилсөн байна (Figure 3).




Figure 3. The structure of diseases

Судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн дийлэнх (57%) нь “Эрүү нүүр орчмын үрэвсэлт өвчнүүд” бүлэгт багтсан өвчнүүдээр өвчилсөн нь харагдаж байна(Figure 3).

Хүүхдийн дунд зонхилон тохиолдож буй Эрүү нүүр орчмын үрэвсэлт өвчний бүлэгт багтсан өвчнөөр өвчилсөн нийт 1881 хүүхдийн 715

нь шүдний гаралтай эрүү нүүр орчмын ясны хальсны үрэвсэл, 641 нь тунгалгийн булчирхайн үрэвсэл, 274 нь шүдний гаралтай эрүү нүүр орчмын нэвчээс, 161 нь эрүү нүүр орчмын зөөлөн эдийн буглаа, 90 хүүхэд эрүү нүүр орчмын ясны үрэвсэл өвчнөөр тус тус өвчилжээ(Figure 4).




Figure 4. Structure of group “Inflammations of maxillofacial area”

“Эрүү нүүр орчмын үрэвсэлт өвчнүүд” бүлгийн өвчний улмаас эмчлүүлэгсдийн дийлэнх нь буюу 715 (38%) нь шүдний гаралтай эрүү нүүр орчмын ясны хальсны үрэвслээр өвчилсөн байна. Энэ нь нийт хэвтэн эмчлүүлсэн хүүхдүүдийн 21.6%–ийг эзлэж байна (Figure 4).

Хүүхдийн дунд зонхилон тохиолдож буй “Эрүү нүүр орчмын үрэвсэлт өвчнүүд” бүлэгт багтсан өвчнүүдээр өвчилсөн нийт 1881 хүүхдийн 1051 эрэгтэй, 830 эмэгтэй, харьяаллын хувьд 1565

хүүхэд УБ хотынх, 316 нь хөдөө орон нутгийнх байжээ.

Эрүү нүүр орчмын үрэвсэлт өвчнөөр өвчилсөн хүүхдүүд насны хувьд 634 (33.7%) нь бага насны хүүхдүүд, 579 (30.8%) нь сургуулийн өмнөх нас, 401 (21.3%) нь сургуулийн бага анги, 179 (9.5%) нь сургуулийн дунд анги, 88 (4.7%) нь сургуулийн ахлах ангийн хүүхдүүд байлаа (Figure 5).




Figure 5. Age index of group “Inflammation of maxillofacial area”

Хүүхдийн дунд зонхилон тохиолдож буй “Эрүү нүүр орчмын үрэвсэлт өвчнүүд” бүлэгт багтсан өвчнүүдээр өвчилсөн хүүхдийн дийлэнх (33.7%) нь бага насны (0-2 нас) хүүхдүүд байгаа нь харагдаж байна (Figure5).

Хэлцэмж

Бидний судалгаанд хамрагдагсдын 57% нь “Эрүү нүүр орчмын үрэвсэлт өвчнүүд” бүлгийн өвчний улмаас хэвтэн эмчлүүлсэн ба дийлэнх нь буюу 38% нь шүдний гаралтай эрүү нүүр орчмын ясны хальсны үрэвслээр өвчилсөн байна. Энэ нь нийт хэвтэн эмчлүүлсэн хүүхдүүдийн 21.6%–ийг эзлэж байгаа нь манай орны хүүхэд залуусын дунд тохиолдох эрүү нүүрний мэс заслын эмгэгүүд дотор шүд цоорох өвчний хүндрэл зонхилж буйг харуулж байна. Ялангуяа бага, сургуулийн өмнөх насны хүүхдүүд энэ өвчнөөр давамгайл өвчилсөн байгаа нь бага насны хүүхдийн дунд шүдний өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой зохион байгуулах, сүүн болон холимог зуултын үеийн цоорлыг эрт үед нь илрүүлж, эмчлэх зайлшгүй шаардлагатайг илтгэж байна. Мөн шүд цоорох өвчний гаралтай эрүү, хоншоор ясны хальсны үрэвслийн улмаас эмчлүүлэгсэд нийт хэвтэн эмчлүүлэгсдийн 21,6%-ийг эзэлж байгаа нь 1, 2-р шатлалын эмнэлэгт эмчлэгдэх боломжтой тул аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн шүдний тусламжийг чадавхжуулах шаардлагатайг харуулж байна.

Хүүхдийн шүд цоорох өвчлөлийн талаарх манай судлаачдын судалгаанаас харахад шүд цоорох өвчний тархалт, эрчим сургуулийн өмнөх насныханд Ц.Норовпил (1986)¹² судалснаар 77.7%, 3.6, Л.Мөнгөнцэцэг (2001)¹³ 75.5%, 5.3, Б.Оюунцэцэг (2005)¹⁴ 96.1%, 8.1, Ж.Дэлгэрцэцэг (2014)¹⁵ судалснаар 92.9%, 8.2 болж жил ирэх тутам нэмэгдсэнтэй холбоотой тухайн өвчний хүндрэл болсон эрүү нүүр орчмын үрэвсэлт,

идээт өвчний тохиолдол сүүлийн жилүүдэд ихсэж байна⁷ гэдэгтэй бидний судалгааны үр дүн ижил байна.

Р.Баясгалан нарын судалснаар ЭХЭМҮТ-ийн ЭНМЗТ-т нийт хэвтэн эмчлүүлэгчдийн дунд шүд цоорох өвчний хүндрэл болох эрүү нүүр орчмын үрэвслийн эзлэх хувь 1999-2006 онд 29.1%-32.0% тохиолдолтой⁸ мөн судлаач Б.Төрболд нарын судалснаар 2014-2016 онуудад хэвтэн эмчлүүлэгчдийн 36.77%-ийг шүд цоорох өвчний хүндрэл болох эрүү нүүр орчмын үрэвсэлт өвчин эзэлж байжээ⁹.

Гадаадын зарим судалгаанаас үзэхэд Тайланд улсын Mahidol болон Khon Kaen их сургуулиудын 0-15 насны 1389 хүүхдийг хамруулсан судалгаагаар хүүхдийн дунд шүдний сурвалжийн оройн ба шүд агуулсан уйланхай хамгийн их тохиолдолтой мөн зөөлөн эдийн идээт үрэвслүүд, шүлсний булчирхайн эмгэгүүд удаалж байсан нь бидний судалгааны дүнгээс нилээд ялгаатай байлаа¹⁶.

Турк улсын эмгэг судлалын зургаан төвд 15 хүртэлх насны хүүхдүүдийг насаар нь гурван бүлэгт ангилан (сүүн зуулт 0-5 нас, холимог зуулт 6-12 нас, байнгын зуулт 13-15 нас), 8 жилийн турш цуглуулсан 472 эдийн шинжилгээний дүнгээс үзэхэд эрүү нүүр орчмын үрэвсэлт өвчин хамгийн их (49%) байсан нь бидний судалгааны дүнтэй ойролцоо байлаа. Мөн энэ судалгаанд насны ангилалыг үрэвсэлт өвчний тохиолдолтой хамаатуулан судлахад холимог зуултын үе буюу 6-12 насны хүүхдүүд дунд өвчлөл зонхилон тохиолдож байжээ¹⁷.

Тайван улсад 1985-1996 оны хооронд 0-15 насны хүүхдээс авсан 534 эдийн шинжилгээнд дүн шинжилгээ хийсэн байна. Хүүхдийн насыг 0-5 нас, 6-10 нас, 11-15 нас гэсэн гурван бүлэг, өвчлөлийг үрэвсэлт өвчин, уйланхайт эмгэг, хавдар болон хавдар төст эмгэг, бусад эмгэг гэсэн 4 бүлэгт авч үзжээ. Үр дүнд нийт

шинжилгээний 16 нь ямар нэгэн өөрчлөлтгүй гарсан ба хамгийн их (46%) нь үрэвсэлт өвчний бүлэг, насны хувьд 11-15 насны хүүхдүүд их байжээ. Хамгийн их тохиолдож байсан эмгэгүүд нь салстын эмгэгүүд, шүдний гаралтай уйланхай, фиброзын дисплази, одонтома байжээ¹⁸.

University College Hospital Ibadan Dental Center төвийн Амны хөндийн эмгэг судлалын төвд 1986-1996 оны хооронд 2264 эдийн шинжилгээний дүнгээр 47,6% нь хавдарт эмгэг, 27,6% нь үрэвсэлт өвчин, 24,8% нь шүдний гаралтай уйланхай хэлбэрийн эмгэг байсан¹⁹ нь мөн л бидний судалгаанаас нилээд ялгаатай үр дүн байв. Ийнхүү бидний судалгаа гадаадын улс оронд хийгдсэн ижил төстэй судалгаануудаас өөр үр дүнг үзүүлж буй нь манай орны эрүүл мэндийн тогтолцооны ялгаа, хүн амын хоол хүнс, амьдрах орчин зэргийн харилцан адилгүй байдалтай холбоотойгоор хүн амын дундах, ялангуяа хүүхдийн дундах өвчлөлийн бүтэц өөрмөц өөр байгаа нь ажиглагдаж байна.

Дүгнэлт:

Судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь эрүү нүүр орчмын үрэвсэлт өвчнүүд (57%) болон УТТС, эрүү нүүр орчмын бусад төрөлхийн гаж хөгжлүүдийн (24.4%) улмаас хэвтэн эмчлүүлжээ.

Эрүү нүүр орчмын үрэвсэлт өвчнүүдээр 0-2 насны хүүхдүүд хамгийн их (33.7%) өвчлөлтэй, хүйсийн хувьд хөвгүүдэд их тохиолдолтой байна. Харьяаллын хувьд 83.2% нь Улаанбаатар хотынх, үүнээс 24.7% нь Баянзүрх дүүргийн харъяалалтай байлаа.

Ном зүй:

- Laskin DM. Textbook of Oral and Maxillofacial surgery, (Ed) Balaji SM. Foreword, Elsevier., 2013, 1:1-3
- Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (ЭХЭМҮТ)-ийн Эрүү нүүрний мэс заслын тасгийн “Оношлогоо эмчилгээний удирдамж” - 2017 он
- Ariuntuul G, Furukawa H, Uetani M, et al. The prevalence of cleft lip and/or palate in Mongolia. J. Jpn. Cleft Palate Assoc., 2006, 31: 267-273
- Аянга Г., Давааням Л., Пүрэвжав Н. Тагнайн төрөлхийн сэтэрхийн мэс заслын эмчилгээний асуудалд, “Эх барих эмэгтэйчүүд, хүүхэд судлал”, 2011, 9:712-716
- Ayanga G., Davaanyam L., Purevjav N., et al. Comparative study of surgical technique for the correction of the congenital cleft palate in Mongolia. J Korean Assoc. Maxillofac. Plas. Reconstr. Surg., 2009, 31: 381-385
- Цэрэн Ц. Некоторые вопросы хирургического лечения детей с врожденными расщелинами губы. Автореферат диссертации на соискание уч. ст. к.м.н, 1980.
- Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Статистик, мэдээлэл зүйн тасгийн 2014-2017 оны тайлан.
- Баясгалан Р., Аянга Г., Амаржаргал О. Хүүхдэд тохиолдох шүдний гаралтай нэвчээс, “Эх барих эмэгтэйчүүд, хүүхэд судлал”, 2011, 9:693-698
- Төрболд Б., Пүрэвсүрэн Б., Эрдэнэцогт Ж. ЭХЭМҮТ-ийн ЭНМЗТ-ын өвчлөлийн бүтцэд хийсэн судалгаа, “Эх барих эмэгтэйчүүд, хүүхэд судлал”, 2017, 21:1505-1510
- <http://www.legalinfo.mn/law/details/6299>
- Цолмон Ч. Хүүхэд, өсвөр үеийн эрүүл мэнд, эрүүл ахуй. УБ, 2013, х.32
- Норовпил Ц., Байгалмаа Б. Шүд судлахуйн үндэс. УБ, 2017, х.95
- Мөнгөнцэцэг Л. Шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчилхэд ургамлын гаралтай зарим бэлдмэлийг хэрэглэх асуудал. УБ, ЭМШУИС, 2001, х.104-119
- Oyuntsetseg B., Okazaki Y., Shimono Ts. Relationship between the salivary buffer capacity test (CAT21 Buf Test) result and caries status in Mongolian preschool children, “Pediatric dental journal”, 2005, 15:115-119
- Дэлгэрцэцэг Ж., Мөнх-Од Ш., Оюунцэцэг Б. Улаанбаатар хотын цэцэрлэгийн насны хүүхдийн шүд цоорох өвчний байдал ба өсөлтийн зарим үзүүлэлт, “Innovation”, 2014, 8(2), х.24-26
- Lapthanasupkul P., Juengsomjit R., Klanrit P., Taweechaisupapong S., Poomsawat S. Oral and maxillofacial lesions in a Thai pediatric population: a retrospective review from two dental schools, “Journal of the Medical Association of Thailand”, 2015 Mar;98(3):291-7
- Гыльтелкин С.Е., Токман В., Тьркseven М.Р. A review of pediatric oral biopsies in Turkey, “International Dental Journal”, 2003 Feb;53(1):26-32
- Chen Y.K., Lin L.M., Huang H.C., Lin C.C., Yan Y.H. A retrospective study of oral and maxillofacial biopsy lesions in a pediatric population from southern Taiwan, “Pediatric Dentistry”, 1998 Nov-Dec; 20(7):404-10
- Lawoyin JO. Pediatric oral surgical pathology service in an African population group: a 10 year review, “Tropical Dental Journal”, 2000 Mar; 23(89):27-30